

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах аюулгүй байдлыг хангах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Цахим хөгжил харилцаа холбооны сайд Н.Учрал нарт үүрэг болгосугай.

Гарын үсэг

ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн салбарын мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Эрүүл мэндийн мэдээллийг "Эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцооны систем" (цаашид "мэдээлэл солилцооны систем")-ээр дамжуулан солилцох бөгөөд энэхүү систем нь төрийн мэдээлэл солилцооны үндсэн (ХУР) системийн бүрэлдэхүүн хэсэг байна.

1.3. Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулж, боловсруулахад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10-д заасан нэгдсэн ангилал, код, тайлбар болон олон улсын стандарт, кодчилал (ICD, FHIR/HL7, SNOMED CT, LOINC)-ыг дагаж мөрдөнө.

1.4. Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан /цаашид "нэгдсэн сан" гэх/ нь нэгдсэн ангилал, код, тайлбарын сан, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээллийн сан, салбарын нөөц, хүчин чадлын мэдээллийн сан, эрүүл мэндийн лавлагаа мэдээллийн сан, бусад төрөлжсөн сангаас бүрдэх бөгөөд энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтад заасан санд хамаарна.

1.5. Энэ журмыг бүх шатны эрүүл мэндийн /цаашид "мэдээлэл хариуцагч" гэх/ болон түүнд эрүүл мэндийн мэдээллийн систем, мэдээллийн сан, программ хангамжийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэгч байгууллага дагаж мөрдөнө.

1.6. Мэдээлэл хариуцагч нь Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсэгт заасны дагуу зарласан программ хангамжийг үйл ажиллагаандаа ашиглана.

Хоёр. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах

2.1. Анхан шатны бүртгэлийн маягт, заавар, эрүүл мэндийн үзүүлэлт тооцох аргачлалыг Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

2.2. Энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан аргачлалын дагуу мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд эрүүл мэндийн мэдээллийг цуглуулж, мэдээллийн санг бүрдүүлж, эзэмшинэ.

2.3. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь нэгдсэн сан, мэдээлэл солилцооны системийн хөгжүүлэлт, хэвийн, найдвартай үйл ажиллагааг хариуцаж, аюулгүй байдлыг хангана.

2.4. Энэ журмын 2.2 дахь хэсэгт заасан мэдээллийн санг бүрдүүлэхдээ төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем, эсхүл эрүүл мэндийн мэдээлэл солилцооны системээс олж авах боломжтой мэдээллийг давхардуулж бүрдүүлэхгүй.

2.5. Мэдээлэл хариуцагч нь мэдээллийг мэдээлэл солилцооны системээр бодит цагийн горимоор солилцох нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6. Мэдээлэл хариуцагч нь мэдээлэлд хандах, шаардлагатай мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах эрхийн тохиргоог хэрэглэгч бүрээр тохируулсан байна.

2.7. Мэдээлэл хариуцагч нь программ хангамжийн сервер, мэдээллийн санг Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журмын 4.4-т заасан шаардлагыг хангасан өрөөнд эсхүл зориулалтын дата төвд байршуулна.

2.8. Мэдээллийн сангийн мэдээллийг Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журамд заасан хугацаанд хадгална.

2.9. Мэдээлэл хариуцагч нь мэдээллийн аюулгүй байдлыг Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 7.1-т заасан нийтлэг журмын дагуу хангана.

2.10. Мэдээлэл хариуцагч нь өөрийн байгууллагын программ хангамж, техник хангамж, мэдээллийн сүлжээний бэлэн байдлыг хангаж, ашиглалт, үйлчилгээнд шаардлагатай зардлыг санхүүжүүлнэ.

2.11. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Мэдээлэл солилцооны системээр солилцох мэдээллийн агуулга, оролт, гаралтын нөхцөл, хувьсагчийг тогтоож, нийтэд ил тод, нээлттэй байршуулна.

2.12. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь нэгдсэн сангийн бүтэц, мэдээлэл солилцооны системд өөрчлөлт оруулах бол өөрчлөлтийн тухай мэдээллийг ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө мэдээлэл хариуцагч, программ хангамж хөгжүүлэгч байгууллагуудад хүргэнэ.

2.13. Программ хангамж хөгжүүлэгч нь эрүүл мэндийн программ хангамжид өөрчлөлт оруулахдаа холбогдох туршилтыг хийж, амжилттай болсны дараа ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө өөрчлөлтийн тухай мэдээлэл, зааврыг мэдээлэл хариуцагчид хүргүүлнэ.

2.14. Мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаа зогссон, татан буугдсан, чиг үүрэг өөрчлөгдсөн бол мэдээллийн санг Эрүүл мэндийн хөгжлийн төв хүлээн авна.

2.15. Мэдээлэл хариуцагч нь программ хангамжийг өөрчилсөн, хөгжүүлэгчийн үйл ажиллагаа зогссон, татан буугдсан бол мэдээллийн санг хүлээн авна.

2.16. Программ хангамж хөгжүүлэгч нь үйлчилгээ үзүүлэхдээ олж авсан мэдээллийг гэрээнд зааснаас бусад зорилгоор ашиглах, хадгалах, гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно.

2.17. Мэдээлэл хариуцагч нь мэдээллийн бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хариуцна.

Гурав.Хариуцлага

3.1. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.